

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/214/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tiv@audit.gov.mn

2022.02.25 № 01/57
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАСАНЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020236

D 2022/2022 он/ALBAN BICHIG

**Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгд
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,994,619.17	67,961,969.17
33	АВЛАГА	644,538.00	2,272,568.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,272,568.00
335	Бусад авлага	644,538.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	94,538.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	550,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,350,081.17	65,689,401.17
351	Түүхий эд материал	545,880.00	397,080.00
35110	Тусгай зориулалттай материал	545,880.00	397,080.00
354	Хангамжийн материал	57,804,201.17	65,292,321.17
35410	Бичиг хэргийн материал	25,352,920.00	24,922,588.00
35420	Аж ахуйн материал	11,786,216.50	12,636,386.50
35430	Сэлбэг хэрэгсэл	2,214,737.00	2,214,737.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	3,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,450,327.67	22,518,609.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	352,745,330.31	415,220,418.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	352,745,330.31	415,220,418.00
392	Биет хөрөнгө	328,438,830.45	391,095,418.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	189,840,500.00	189,840,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,894,806.14	-21,264,450.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	102,415,500.00	159,715,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-102,415,500.00	-107,860,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	424,793,161.82	480,449,929.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-291,733,532.13	-326,407,097.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,565,760.82	76,565,760.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,132,253.92	-59,944,224.42
393	Биет бус хөрөнгө	24,306,499.86	24,125,000.00
39301	Програм хангамж	3,160,000.00	3,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,978,500.14	-3,160,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,125,000.00	24,125,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	411,739,949.48	483,182,387.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	411,739,949.48	483,182,387.17
51	Засгийн газрын хувь оролцоо	411,739,949.48	483,182,387.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	345,023,143.41	345,023,143.41
51101	Өмч: - төрийн	345,023,143.41	345,023,143.41
512	Хуримтлагдсан үр дүн	-32,492,413.46	38,950,024.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-32,492,413.46	-32,492,413.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	71,442,437.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,209,219.53	99,209,219.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	411,739,949.48	483,182,387.17

**Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	911,418,231.67	856,963,759.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,013,498.00	60,150,991.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,013,498.00	60,150,991.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,013,498.00	60,150,991.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,435,238.00	22,111,123.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,578,260.00	38,039,868.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	187,452,033.67	161,048,268.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	676,952,700.00	635,764,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,852,147.00	132,439,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,352,147.00	132,439,368.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,859,100.00	26,505,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,859,100.00	26,505,900.00
1330	Төсвийн захирагчдаас	9,740,786.67	2,103,000.00
133003	Хөрөнгийн	9,740,786.67	2,103,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	860,087,620.44	785,521,321.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	860,087,620.44	785,521,321.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	658,814,251.94	702,728,627.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,501,892.00	471,860,795.00
210101	Үндсэн цалин	469,501,892.00	376,075,330.00
210102	Нэмэгдэл	00.00	91,559,734.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	4,225,731.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,180,139.37	61,433,248.00
210201	Тэтгэврийн даатгал	62,180,139.37	48,639,255.64
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,567,399.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,460,464.84
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	615,066.25
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,151,062.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,383,205.00	20,650,690.00
210301	Гэрэл, цахилгаан	2,780,575.00	2,650,840.00
210302	Түлш, халаалт	15,750,240.00	15,750,240.00
210303	Цэвэр, бохир ус	852,390.00	2,249,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,171,116.00	40,961,207.00
210401	Бичиг хэрэг	24,819,217.00	23,833,900.00
210402	Тээвэр, шатахуун	30,824,900.00	14,985,807.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	683,659.00	475,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,843,340.00	1,665,640.00
2105	Нормативт зардал	00.00	395,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	395,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,732,900.00
210604	Урсгал засвар	00.00	2,732,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,592,000.00	19,165,000.00
210702	Дотоод албан томилолт	2,592,000.00	19,165,000.00

Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,325,900.00	6,232,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,072,700.00	6,232,019.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	55,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,659,999.57	79,296,918.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,759,930.00	28,815,238.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,900,069.57	50,481,680.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,273,368.50	82,792,694.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,157,500.00	1,520,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,520,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,197,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,960,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,352,818.50	1,162,178.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,352,818.50	1,162,178.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	64,327,812.00	5,511,106.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,327,812.00	5,511,106.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,435,238.00	74,599,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,435,238.00	16,451,123.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	44,000,000.00	58,148,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	51,330,611.23	71,442,437.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	51,330,611.23	71,442,437.69

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.41	98,918,819.53	-83,823,024.69	00.00	360,118,938.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,023,143.41	98,918,819.53	-83,823,024.69	00.00	360,118,938.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,011,241.73	00.00	137,011,241.73
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.41	99,209,219.53	-32,492,413.46	00.00	411,739,949.48
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.41	99,209,219.53	-32,492,413.46	00.00	411,739,949.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,023,143.41	99,209,219.53	-32,492,413.46	00.00	411,739,949.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	71,442,437.69	00.00	71,442,437.69
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,023,143.41	99,209,219.53	38,950,024.23	00.00	483,182,387.17

**Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	899,099,185.00	816,820,891.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,435,238.00	22,111,123.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,435,238.00	22,111,123.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,435,238.00	22,111,123.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,435,238.00	22,111,123.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,663,947.00	794,709,768.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	676,952,700.00	635,764,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,852,147.00	132,439,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,352,147.00	132,439,368.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,859,100.00	26,505,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,859,100.00	26,505,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	863,006,585.00	741,903,991.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	863,006,585.00	741,903,991.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	661,733,216.50	655,345,697.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,199,099.33	471,860,795.00
210101	Үндсэн цалин	375,140,759.69	376,075,330.00
210102	Нэмэгдэл	82,715,315.64	91,559,734.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	902,700.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,440,324.00	4,225,731.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,417,413.17	61,433,248.00
210201	Тэтгэврийн даатгал	56,116,040.59	48,639,255.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,227,696.39	3,567,399.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	935,116.96	2,460,464.84
210204	Ажилгүйдлийн даатгал	233,779.34	615,066.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,904,779.89	6,151,062.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,383,205.00	20,650,690.00
210301	Гэрэл, цахилгаан	2,780,575.00	2,650,840.00
210302	Түлш, халаалт	15,750,240.00	15,750,240.00
210303	Цэвэр, бохир ус	852,390.00	2,249,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,838,000.00	21,203,760.00
210401	Бичиг хэрэг	6,896,400.00	6,742,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,095,600.00	12,320,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,900.00	475,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,100.00	1,665,700.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,296,250.00	2,732,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,900,900.00	00.00
210604	Урсгал засвар	1,395,350.00	2,732,900.00
2107	Томиллолт, зочны зардал	2,592,000.00	19,165,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,592,000.00	19,165,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,404,869.00	6,232,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,206,869.00	6,232,019.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,206,380.00	51,671,285.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,206,380.00	51,671,285.00

**Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,273,368.50	86,558,294.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,157,500.00	5,285,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,285,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,197,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,960,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,680,630.50	1,162,178.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,162,178.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	5,511,106.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,511,106.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,435,238.00	74,599,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,435,238.00	16,451,123.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	44,000,000.00	58,148,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,092,600.00	74,916,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,092,600.00	74,916,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,092,600.00	74,916,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,092,600.00	74,916,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,092,600.00	74,916,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-36,092,600.00	-74,916,900.00

**Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангил	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	662,270,400.00	657,985,912.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	662,270,400.00	657,985,912.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,310,400.00	652,700,312.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,199,100.00	471,860,795.00
210101	Үндсэн цалин	364,418,000.00	376,075,330.00
210102	Нэмэгдэл	84,457,100.00	91,559,734.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,694,700.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	7,629,300.00	4,225,731.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,476,800.00	61,433,248.00
210201	Тэтгэврийн даатгал	44,668,900.00	48,639,255.64
210202	Тэтгэмжийн даатгал	4,702,000.00	3,567,399.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,761,600.00	2,460,464.84
210204	Ажилгүйдлийн даатгал	940,400.00	615,066.25
210205	Эрүүл мэндийн даатгал	9,403,900.00	6,151,062.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,773,000.00	20,650,690.00
210301	Гэрэл, цахилгаан	1,473,000.00	2,650,840.00
210302	Түлш, халаалт	19,733,900.00	15,750,240.00
210303	Цэвэр, бохир ус	2,566,100.00	2,249,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,132,600.00	20,203,760.00
210401	Бичиг хэрэг	6,896,400.00	6,742,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,390,200.00	11,320,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,900.00	475,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,100.00	1,665,700.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,732,900.00	7,732,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,732,900.00	2,732,900.00
2107	Томиллолт, зочны зардал	19,200,600.00	19,165,000.00
210702	Дотоод албан томиллолт	19,200,600.00	19,165,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	6,485,600.00	6,232,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	6,250,000.00	6,232,019.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,913,800.00	45,025,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,913,800.00	45,025,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,960,000.00	5,285,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,960,000.00	5,285,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,960,000.00	5,285,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	662,270,400.00	657,985,912.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	635,764,500.00	634,602,322.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	635,764,500.00	634,602,322.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,505,900.00	23,383,590.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,505,900.00	23,383,590.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	46.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	5.00

Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,569,880	15,262,285.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,569,880	15,262,285.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,262,285.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,569,880.00	14,262,285.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,569,880.00	14,262,285.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		62,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		62,300,000.00
222001	Тоног төхөөрөмж		62,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	148,852,147.00	132,439,368.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,852,147.00	132,439,368.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	3,500,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,352,147.00	132,439,368.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн ГХБХБГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн ГХБХБГ нь газрын харилцаа барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хот байгуулалт хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй шуурхай үзүүлэх, Барилга хот байгуулалтын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн ГХБХБГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.
Үүнд:

- Газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 384 дугаар тушаалаар батлагдсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2012 оноос хойш шинэчлэгдэн өөрчлөгдсөн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын өөрчлөлт хийгдээгүй байна.

ГХБХБГ-ын даргын 2021 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дарга, 3 гишүүнтэйгээр томилж, журмыг хавсралтаар баталсан байна. Дотоод хяналт шалгалтын 2021 оны төлөвлөгөөг 6 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулсан батлуулсан байна. Дотоод хяналт шалгалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 4 арга хэмжээнд гаргасан ба 2 арга хэмжээ хугацаа болоогүй байна.

Санхүү, хяналт аудитын алба нь 2021 оны 03 дугаар сард тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд болон газрын төлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн ГХБХБГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн ГХБХБГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас 1,5 хувиар буюу 12,945.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,356.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас 1,5 хувиар буюу 12,252.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,801.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 692.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн ГХБХБГ нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн алба нь “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 635,764.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 26,505.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлогоор 22,111.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтийн дансанд 132,439.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 816,820.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэл дансанд 36,300.0 мянган төгрөгийн, тоног төхөөрөмж дансанд аймгийн хөрөнгө оруулалтаар 35,000.0 мянган төгрөгийн, ГЗБГЗЗГ-аас 3,039.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 38,616.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн тайлагнасан, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Бараа материалын дансанд ГЗБГЗЗГ-аас 2,103.0 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр 64,761.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 59,525.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2,272.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өглөгийн 0 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Жилийн эцсийн байдлаарх авлага нь ХАОАТ-т 2,272.5 мянган төгрөгийг илүү шилжүүлснээс үүссэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө 0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 65,689.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 427,090.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	644.5	2,272.6	1,631.1
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	58,350.1	65,689.4	7,339.3
Үндсэн хөрөнгө	352,745.3	427,090.3	74,345.0
Нийт хөрөнгө	411,739.9	495,052.3	83,312.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	411,739.9	495,052.3	83,312.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	411,739.9	495,052.3	83,312.4

Бараа материалын дансны үлдэгдэл 65,689.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 7,339.3 мянган төгрөгөөр өссөн нь түлш, шатах тослох материалын болон бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 427,090.3 мянган төгрөг болж 74,345.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 112,956.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 495,052.3 мянган төгрөг болж 83,312.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 703,977.1 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 51,927.4 мянган төгрөгөөр бууруулан 652,049.7 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Тайлант хугацаанд төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 662,270.4 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 635,764.5 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 26,505.9 мянган төгрөгийн, нийт 662.270.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авч, урсгал үйл ажиллагаандаа 657,985.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,284.5 мянган төгрөгийг улсын төсөвт 1,162.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 3,122.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 657,985.9 мянган төгрөг буюу 99,4 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хувийн хэргийн үнэнд 22,816.8 мянган төгрөг, үйлчилгээний орлогоор 6,954.9 мянган төгрөг, техник хяналтын зардалд 65,509.9 мянган төгрөг, нийт 95,281.6 мянган төгрөг төвлөрч, ГЗБГЗЗГ-т 74,599.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, ГЗБГЗЗГ-аас нэмэлтийн орлогыг зарцуулах чиглэл зөвлөмж өгөгдсөн дагуу нийгмийн даатгалын шимтгэлд 8,486.8 мянган төгрөг, багаж, сэлбэг, шатахууны үнэнд 11,775.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус дансаар өмнөх онд аймгийн төсөвт төвлөрүүлсэн 59,265.4 мянган төгрөгийн орлогыг аймгийн Засаг даргын захирамжаар буцаан төвлөрүүлж 36,300 мянган төгрөгөөр автомашин, ЛАНД 200 машины моторын үнэнд 21,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 2,388.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн дансанд аймгийн хөрөнгө оруулалтаар 35,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ГЗБГЗЗГ-аас 3,039.8 мянган төгрөгийн компьютер, ГЗБГЗЗГ-аас нэмэлтийн орлогыг зарцуулах чиглэл зөвлөмжийн дагуу Хьюндай старекс маркийн авто машин 36,300.0 мянган төгрөгөөр, ЛАНД 200 машины мотор 21,000.0 мянган төгрөгөөр, phantom 4RTK 2021 багаж 5,000.0 мянган төгрөгөөр, гадна гэрэлтүүлэг 2,731.5 мянган төгрөгөөр бэлтгэсэн ба тайлант оны бараа үйлчилгээний бусад зардлаас 2,239.8 мянган төгрөгөөр 2ш принтер, 2,046.0 мянган төгрөгөөр компьютер дэлгэц, эд хогшил, урсгал засварын зардлаас 999.8 мянган төгрөгөөр принтер, 4,599.8 мянган төгрөгөөр компьютер дэлгэц, нийт 38,616.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн байна.

Тайлант онд бэлтгэсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа, тендер сонгон шалгаруулалт болон техник хяналтын зардлын гэрээ хэлцэл цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад хамрагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх онд аймгийн төсөвт төвлөрүүлсэн 59,265.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/169 дүгээр захирамжаар буцаан төвлөрүүлж, Солонгос улсын Хьюндай старекс маркийн авто машины үнэнд 36,300.0 мянган төгрөг, Ланд 200 машины моторын үнэнд 21,000.0 мянган төгрөг, ГЗБГЗЗГ-аас нэмэлтийн орлогыг зарцуулах чиглэл зөвлөмж өгөгдсөн дагуу нийгмийн шимтгэлийн зардалд 8,486.8 мянган төгрөг, багаж, сэлбэг, шатахууны үнэнд 11,775.4 мянган төгрөгийг тус зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 4 мэдээллийг огт байршуулаагүй, 14 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна. Үүнд: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, Худалдан авах ажиллагааны тайлан зэрэг 4 мэдээллийг бүтэн жилээр байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад 3 зөвлөмж өгөгдсөн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 07/381 дугаар албан бичгээр ирүүлсэн ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 131,164.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 112,490.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,272.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 16,401.1 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн дансны зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Санхүү үр дүнгийн тайланд өмнөх үеийн үр дүн 85,680.6 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд нийт цэвэр мөнгөн гүйлгээ 349.9 мянган төгрөгөөр, санхүү үр дүнгийн тайланд шатахууны зардлыг 5,460.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тайлант онд худалдан авсан Ланд 200 машины моторын үнэ 21,000.0 мянган төгрөгийг капиталжуулан бүртгэлгүйгээр, үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд буруу ангилан бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд харилцагч байгууллагатай тооцоог нийлж, төлбөрийн тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс ХАОАТ-т 2,272.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар шинээр авлага үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Байгууллагын даргын 2021 оны 5 дугаар сарын 17-ны А/23 тушаалаар ажилчин албан хаагчдын хүүхдүүдийн витаминжуултад 1,819.0 мянган төгрөг, даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/65 дугаар тушаалаар албан хаагчдыг эмнэлгийн үзлэгт хамруулсан төлбөрт 4,940.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийн зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг Е баримттай тулгалт хийхэд 9,642,1 мянган төгрөгийн гүйлгээний Е баримт зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй

Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 4 мэдээллийг огт байршуулаагүй, 14 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна. Үүнд: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, Худалдан авах ажиллагааны тайлан зэрэг 4 мэдээллийг бүтэн жилээр байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд үнэн зөв иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр

Д / д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	ГХБХБГ	6	131,164.1	2	112,490.5	1	2,272.5	2	16,401.1	1	0

